



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/276

Чингис хот

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр
хэрэгжүүлэхэд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а", Авлигын эсрэг хуулийн 6.1.14, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд зориулж 4.000.000 /дөрвөн сая/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.
2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.
3. Шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2020 оны
 06 дугаар сарын 09 өдрийн А/ДТГ
 дугаар захирамжийн хавсралт

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭНТИЙ АЙМАГТ 2020 ОНД
 ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ТООЦОО

Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа	№	Аймгаас хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр	Хоёр дахь үе шат (2020-2023 он)		Хэрэгжүүлэх байгууллага
					Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	
Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр							
4.1.1.7-нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, харууцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх	1	Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Иргэдээ сонсье 70563111 утсаар мэдээлэл авах үйл ажиллагааг зохион байгуулах./зурагт хуудас/	2020	Орон нутгийн төсөв	Өргөдөл, гомдол, мэдээллийг шуурхай хүлээн авч хэвшсэн байна.	250.000	АЗДТГ Бүх шатны төрийн байгууллага
	2	ЭБАТ-ны багийг төрийн байгууллага, сумдад тусгай удирдамжийн дагуу ажиллуулж дотоод хяналтыг сайжруулна.	2020	Орон нутгийн төсөв	Дотоод хяналт сайжирсан байна.		ЭБАТ-ны баг Бүх шатны төрийн байгууллага
	3	Шинэчлэн батлагдсан захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудын албан хаагчдад сурталчлах.	2020	Орон нутгийн төсөв	Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаа жигдэрсэн байна.	250.000	АЗДТГ, ТАЗСЗ Бүх шатны төрийн байгууллага
4.1.1.10-нийтийн албаны сургалтын байгуулах, тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх	1	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Бүх нийтийн эрх зүйн боловсрол" дэд хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчидруу чигэлсэн сургалтыг тухайн жилийн төлөвлөгөөний дагуу зохион байгуулах.	2020	Орон нутгийн төсөв	Сургалтын ерөнхий төлөвлөгөө батлагдаж сургалт зохион байгуулагдсан байна.	500.000	АЗДТГ, ТАЗСЗ, Бүх шатны төрийн байгууллага
	2	Орон нутгийн эрх бүхий 30 албан тушаалтныг чадавхижуулах сургалтыг зохион байгуулж тэдгээрээр дамжуулан Авлигын эсрэг хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах албан хаагчдад	2020	Орон нутгийн төсөв	Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах нийт албан хаагчийг	500.000	АТГ, АЗДТГ, ТАЗСЗ, Бүх шатны төрийн байгууллага

	Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах.			сургалтад хамруулсан байх		
4.1.2.1. төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх бүрдүүлэн, цахим үйлчилгээний сүлжээ бий болгож бэхжүүлэх.	Төрийн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх боломжтой үйлчилгээг шилжүүлэх арга хэмжээ авах.	2020	Орон нутгийн төсөв	Цахим хэлбэрээр үзүүлэх төрийн боломжит үйлчилгээний жагсаалтыг гаргаж цахим хэлбэрт шилжүүлсэн байна.	1.160.000 0	Бүх шатны төрийн байгууллага
4.1.2.2. төрийн үйлчилгээний хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах	Орон нутгийн төрийн байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмжид жил тутамд хөндлөнгийн үнэлгээ хийж хэвшүүлэх.	2020		ТББ, мэргэжлийн холбоо, хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар жил тутамд үнэлгээ хийлгэсэн байх	АЗДТГ	Бүх шатны төрийн байгууллага
2	Орон нутгийн Төрийн байгууллагын албан хаагчдын үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлэх.	2020		Төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд иргэд үнэлгээ өгөх ажил тогтмолжсон байх	АЗДТГ	Төрийн үйлчилгээний байгууллага
Арав. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр						
4.1.10.1. авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	Цахим орчин болон орон нутгийн телевизээр нэвтрүүлэх шторк, нэвтрүүлэг хийх.	2020	Орон нутгийн төсөв	Шударга ёсны санаа нийгэмд төлөвшиж, иргэн өөрт учирч байгаа хүндрэл, бэрхшээлийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх мэдлэгтэй болсон байна.	640.000	Сумын Засаг даргын Тамгын газар
2	Эссэ бичлэгийн болон гар зургын уралдаан зарлах.				700.000	АЗДТГ